

## МОНГОЛ ХЭЛНИЙ "БЭР" ХЭМЭЭХ ҮГИЙН ГАРЛЫГ МӨШГӨХ НЬ

Д.Соронзон (магистр)  
МУБИС. МоСС. Монгол хэл шинжлэлийн  
тэнхимийн багш

Монгол хэлний төрөл садны нэрс нь утга, бүтцийн талаас олон мянган жилийн турш хувьсаж хөгжиж ирэхдээ монгол туургатны нийгмийн хөгжлийн үе шатны онцлог шинжүүдийг өөртөө шингээсэн нэрлэлтийн нэгэн өвөрмөц тогтолцоог бий болгожээ.

Ер төрөл садны нэрс нь хүн төрөлхтний нийтлэгийн хамгийн анхдагч хэлбэр болох гэр бүл бий болж, ясан ба цусан төрлийн холбоог ялгах хэрэгцээнээс үүдэн бий болжээ. Ингэж үзвэл гарал үүсэл нь харьцангуй эртний үзэгдэл болно.

Эдгээр үгс нь судлаачдын сонирхлыг зүй ёсоор татаж, улмаар судалгаа шинжилгээний ажил цөөнгүй хийгдсэн боловч, тэдгээрт гол төлөв төрөл садны нэрсийн утга агуулга, бүрэлдэхүүнийг тодорхойлох талын судалгаа давамгайлж, харин гарал бүтцийн талыг нь судалсан зүйл харьцангуй бага байна. Гэтэл аливаа хэлний төрөл садны нэрс нь гарал үүслийн хувьд тухайн хэлний уугуул үгсийн дотроос харьцангуй эрт үеийн онцлогийг тусгасан байх тул үгийн гарал зүйн үүднээс бусад олон үгийн анхдагч бүтэц, утгыг тодорхойлоход чухал ач холбогдолтой билээ. Түүний жишээ болгож уг илтгэлдээ бид "бэр" хэмээх үгийн гарлыг тайлбарлах зорилго тавилаа.

Проф. М. Базаррагчаа, Өвөрмонголын эрдэмтэн Хасбаатар нар уул үгийн гарлыг тодорхойлж, улмаар хэзээ үүссэн тухай асуудлыг түүх нийгмийн зохих баримтаар тайлбарласан байна. (2, 9:46-50)

Академич Ш. Лувсанвандан "Үгийн язгуурыг судлахад түүхийн үүднээс, мөн хэлний хөгжлийн нэг үеийн байдлаар судалж болно. Хэл нь түүхт үзэгдэл болох учир мөн үгийн язгуур ч түүхт үзэгдэл болно. Хэлний хөгжлийн нэг үед идэвхтэй үйлчилж байсан үгийн язгуур нөгөө үед мөхөн сөнөж мэдэгдэхгүй байж болно." хэмээн бүтэц, байрлалын үүднээс үгийн идэвхгүй язгуурыг түүхэн бүтээврийн талаас авч үзсэн нь үгийн гарал судлалын үүднээс чухал ач холбогдолтой зүйл юм. (5:103)

Энэ байдалд үндэслэн "бэр" гэх үгийг бид түүхэн үүднээс "be-ri" гэсэн бүтээврүүд болгон задалж, түүхэн бүтээвэр тус бүрийн утга, үүргийг тодорхойлох болно.

### 1. "\*be" – Эм хүйс заасан түүхэн бүтээвэр болох нь

Монгол хэлний төрөл садны нэрсийн бүтцийг ажиглавал, зохих тооны бүтээврүүд язгуур ба залгавар бүтээврийн төвшинд өөр хоорондоо нарийн зүй тогтлоор холбогдон тогтсон байдгийг мэдэж болно. Тухайлбал, үеийн хүрээнд буюу орон зай хэмжигдэхүүний дотор, эшийн төвшинд буюу цаг хугацааны хувьд тодорхой харьцаа заан нэрлэсэн, эсвэл дээрх хоёрын алинд нь ч багтахгүй эр, эм хүйсээр ялгасан бүтээврүүд язгуурын байранд тохиолдож байхад харин залгавар бүтээврийн байранд тохиолдох тухайн бүтээврүүд нь хүндэтгэсэн, тоогоор болон хүйсээр ялгасан зэрэг олон янзын утгатай байдаг ажээ.

Тэдгээрийн дотроос монгол хэлэнд хүйс ялган төрөл садны нэр бүтээж байсан зарим түүхэн бүтээврийг дор харьцуулан үзүүлье.

Монгол хэл, бичгийн баримтаас ажиглавал, төрөл садны нэрсийн бүтцэд язгуур болон залгаврын төвшинд *ba/be/~ma/me/* гэсэн бүтээврүүд тохиолдох бөгөөд тэдгээр нь мөн *bu/bü/~bo/bö/ (~mu/mü/)* гэсэн бүтээврүүдийн эгшиг авиатай уруулын шинжээр эсрэгцэн хүйс ялгах үүрэгтэй байжээ. Жишээ нь:

### Эм хүйс заасан нэрс

Мо. а – **ba** – *γai* /авгай-эхнэр/  
 Мо. а – **ba** – *qai* /авхай/  
 Мо. а – **bai** /авай/ Уг “bai-” бүтээвэр нь  
*bai-dasu* /байдаc/, *su-bai*/сүвай/  
 зэрэг үгийн бүтцэд бий.  
 Мо. **be** – *ri* /бэр/  
 Мо. **be** – *r(i) – gen* /бэргэн/  
 Вир. **ba** – *sa – γan* /охин/

*b ~ m*

Мо. е – **me** – *gen* /эмгэн/  
 Бао. а: - **me** ~ а – **mo** /ээж/  
 Вир. **ha** – **ma** – *γan* /эхнэр, авгай/  
 Дун. а: - **ma** /эх/

### Эр хүйс заасан нэрс

Мо. а – **bu** /аав/  
 Мо. а – **bu** – *γai* /авгай-эр хүнийг  
 хүндэтгэн дуудах нэр/  
 Мо. е – **bü** – *gen* /өвгөн/  
 Мо. о – **bu** – *γ* /овог/  
 Бао, Дун. **bu** – *dzu* /ястан/  
 Бао. а – **bo** /аав/

*b ~ m*

Мо. о – **tu** – *γ* /омог/

Дээр давтагдаж буй дурдсан бүтээврүүд нь хэлний хөгжлийн нэн эрт цагт эмэгтэй хүнийг заасан үе бүтээвэр байсан бөгөөд тэдгээрийг цаашид төрөл садны нэрсэд хадгалагдан үлдсэн байна.

Ингэхдээ үе бүтээвэр нь нэг талаас хэлзүйн харьцаа заасан залгавар болох, нөгөө талаас үгийн сангийн харьцаа заасан бүтээвэр болдог байсан бололтой. Хоёр дахь тохиолдол нь эхнийхээсээ нэн эртнийх бөгөөд эдүгээ тэр нь авиалбар ба бүтээврийн завсрын төвшний нэгж хэмээн үзэж болохоор тийм хоёрдмол шинжийг агуулсан үзэгдэл болсон байна.

Энэ нь өвөг алтайн болон өвөг монгол хэлэнд үе бүтээвэр нь нэрлэлтийн үндсэн нэгж болох үгтэй дүйж байсан үеийн ул мөр бөгөөд энэхүү үе бүтээврүүд нь тонгорох, давтах, хорших, зарим тохиолдолд оруулбар, угтварын үүрэгтэй байсныг проф. М. Базаррагчаа, Т. А. Бертагаев нарын бүтээлүүдэд тодорхой дурдсан байдаг.

## 2. “-ri” - Үйл хөдлөл заасан утгатай бүтээвэр болох нь

Аливаа юм үзэгдэл өөрт нь оноож өгсөн тухайн нэртэйгээ холбоотой байдаг эсэх тухай маргаанаас үүдэн эртний грекийн гүн ухаантан Платон (МЭӨ 428-384) “Кратил” хэмээх зохиолдоо үгийг бүтээж байгаа авиа, тухайн ухагдахуун хоёр хоорондоо холбоотой байдгийг дурдаад “r” авиа ямагт хөдөлгөөнийг заадаг (*tromos* /чичрэх/, *roe* /хөдөлгөөн/) бол “l” авиа нь гол төлөв өөгүй, тэгшхэн гэсэн утга (*linaros* /тослог/, *legos* /өөгүй/) илтгэдэг. Ийм баримтад тулгуурлан зарим үгийн гарлыг тайлбарлаж болно. Гэвч эдгээр үг нь нэн эртнийх төдийгүй хүмүүс түүнээс хойш өдий төдий олон үг зохион хэрэглэж ирсэн тул авиа ба ухагдахуун хоёрын хоорондох харьцааг тогтооход бэрхтэй болсон хэмээн тэмдэглэж байжээ. (4:14-15)

Үүний адилаар монгол хэлний тонгоруу толь (1) - д байгаа “-ri” төгсгөлт зарим үгийн утгыг хянан үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Мо. <i>jo-ri</i> (зорь-)	- нэг цэгээс нөгөө цэгт хүрэхээр зорчих
Мо. <i>bömbü-ri</i> (бөмбөр-)	- бөөрөнхий юмын орчиж явах
Мо. <i>qa-ri</i> (харь-)	- гэр нутагтаа буцах, эгэх
Мо. <i>keltü-ri</i> (хэлтэр-)	- хэргээс зайлж мултрах
Мо. <i>qolbi-ri</i> (холбир-)	- юмнаас мултран унах
Мо. <i>uqu-ri</i> (ухар-)	- гэдрэг явах гэх зэрэг олон үгс байх ба тэдгээрт

байгаа “-ri” бүтээвэр нь тодорхой чиглэл, зорилго бүхий хөдөлгөөний утга илтгэж байна.

Үүний адилаар “бэр” хэмээх үгэнд тохиолдож буй “-ri” ч мөн ийм утгатай байжээ. Түрэг хэлнүүдийн үгийн гарлын толь бичигт *kelin* /бэр/ хэмээх үгийг *kel* /урэх/ гэсэн үйл үгээс гаралтай хэмээн олон судлаачийн дурдсаныг тэмдэглэсэн нь монгол түрэг хэлэнд ийм нэрлэлтийг үүсгэсэн дотоод нөхцөлийн тал нь адил байгааг харуулж байна. (7:16-18)

Түүнчлэн зарим түрэг хэлэнд “нааш” гэсэн утга бүхий *be:r* (<\*be+ri) гэх үгийн төгсгөлийн “r” (<\*ri) – ийг “наашаа” гэсэн утгатай бүтээвэр хэмээн тэмдэглэжээ. (8:337-338) Тэр нь эртний түрэг хэлэнд *beri* [berü] гэсэн хэлбэр, “наашаа” гэх утгатайгаар хэрэглэгдэж байсан байна. (7:91, 96)

Эцэст бэр гэх үг хэрхэн үүссэн талаарх өөрийн саналыг батлахын тулд хэзээ үүссэн тухай асуудлыг тодруулбал зүйтэй байна. Нийгмийн хөгжлийн эрт үед гэрлэж байгаа хоёр хүний эрэгтэй нь эмэгтэйнхээ талд очиж амьдардаг байсан бөгөөд энэ үед “хүргэн” гэдэг нэрлэлт бий болсон байна. Харин хөгжлийн дараагийн шатанд эмэгтэй нь эрэгтэйнхээ талд ирж суух болсноор “бэр” гэх нэрлэлт үүсжээ. Иймд “хүргэн” гэдэг ойлголт нь “бэр” гэдгээсээ өмнө үүссэн бөгөөд улмаар магад эдүгээ бидний “хүр дүү” хэмээн хэлэлцэж буй “хүр” /\*kü+ri/ гэсэн хэлбэрээр тэмдэглэгдэж, хойшид “бэр” /\*be+ri/ гэдэг үгийг өөрийн бүтцийн аналогитор үүсгэсэн бололтой. Хойшид “хүргэн” /\*kü+ri+ge+n/, “бэргэн” /\*be+ri+ge+n/ гэх нэрс үүсэж агуулгын хувьд хувьссанаар одоогийн утгыг илтгэх болсон байна.

Энэхүү “ri” бүтээврийн “i” эгшиг нь дундад үеийн монгол хэлний үе хүртэл авиалбарын үүргээ тогтвортой хадгалж байсныг холбогдох бичгийн дурсгалуудааас үзэж болох бөгөөд (6:85-86) эдүгээ ч олон монгол хэлэнд *beri* (*Mngr, SY, Dag, Bur.*), *beiri* (*Mog.*), *bieri* (*Mngr, Dun.*) гэх зэргээр “i” авиалбараа хадгалсаар байна.

Иймд хүү (охин) – гийн талынхан охин (хүү) – ы хувьд хадам буюу харь элгийн хүмүүс болно. Монгол хэлэнд байгаа “ха-” язгуурт зарим үгсэд “харь” гэсэн утга хадгалагдаж буй нь үүнтэй холбоотой. Улмаар хүү ба охины талынхан хоорондоо худ, худгуй нар болно. Энэ нь бусад хулжих, хуланц мэтийн “ху-” язгуурт үгсийн нэгэн адил хулжиж одсон буюу тодорхой хамаа сүлбээтэй болохыг заах ажээ.

### Дүгнэлт

Монгол хэл, бичгийн дурсгалаас үзвэл, бэ-/ба-/ бүтээвэр нь бү-/бу-/ бүтээвэртэй эсрэгцэн эм хүйсийг зааж, улмаар -ри хэмээх дагаврыг өөртөө татан шингээснээр “Ирсэн эмэгтэй” гэсэн утгатай нэгэн үг болон тогтжээ.

Аливаа улс үндэстний нийгмийн хөгжлийн хувьсал өөрчлөлтийг хамгийн ихээр мэдэрч, өөртөө тэр хэмжээгээр тусгадаг хэлний төвшин нь үгийн сан болох тул монгол хэлний төрөл садны нэрс нь ураг төрөл, садан төрлийн холбоо харьцааг заан илтгэхийн зэрэгцээ ураг хуримын ёс, гэр бүлийн үүсэл, түүний хувьсал хөгжлийг тусгасан онцлогтой байна.

### Ном зүй

1. Баатар., Монгол хэлний үүсмэл үгийн тонгоруу толь, *ӨМАХХ*, 1988,
2. Базаррагчаа, М., Монгол үгийн гарлыг мөшгөх нь, *Уб.*, 1992,
3. Древнетюркский словарь, *АН СССР, Институт языкознания, Л.*, 1969, 677 с
4. Иванова, Л. П., Курс лекций по общему языкознанию, *Киев*, 2006, 307 с
5. Лувсанвандан, Ш., Орчин цагийн монгол хэлний бүтэц, дэд дэвтэр, монгол хэлний үг нөхцөл хоёр нь, *Уб.*, 1999
6. Рыкин, П. О., Семантический анализ терминов родства и свойства в среднемонгольском языке, *Вопросы филологии. Урало-алтайские исследования, - УА. 1(2009)*
7. Севортян, Э. В., Этимологический словарь тюркских языков, *В, Г и Д, М.*, 1980, 395 с
8. Татаринцев, Б. И., Этимологический словарь Тувинского языка, 1, (А-Б), *Новосибирск*, 2000, 341 с
9. Хасбаатар., Монгол хэлний төрөл садны зарим нэрийдлийн үүслийн тухай, - *МС. 3(1992)*

## ***Товчилсон нэрсийн жагсаалт***

*Bao.*           *Баоань хэл*  
*Bur.*           *Буриад хэл*  
*Dag.*           *Дагур хэл*  
*Dun.*           *Дунсян хэл*  
*Mng.*           *Монгол хэл*  
*Mog.*           *Могол хэл*  
*SU.*            *Шар Уйгур хэл*

*Mo.*            *Монгол бичгийн хэл*

*АН СССР*    - *Академия Наук СССР*  
*МС*            - *Монголын судлал*  
*ӨМАХХ*       - *Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо*

## ***Резюме***

*Монгольские слова - термины родства изменялись и развивались в течении многих тысячелетий по своему составу значению они отражают особенности каждого этапа развития общественно – семейного развития монгольских племен.*

*Эти слова вызвали интерес у ученых, которые основном, изучали проблемы значений и составляющего слов – терминов родства по отцовский и материнский линии, в меньшей степени затраивали происхождения этих слов или объясняли с точки зрения этимологии.*